



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/179

Мандалговь

Сургалтын төлбөрийн дэмжлэг  
үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Дундговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн “Хүний нөөцийг хөгжүүлэх” дэд хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулан батлах тухай 61 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан Дундговь аймгийн “Хүний нөөцийг хөгжүүлэх” дэд хөтөлбөрийн 4.2.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутагт нэн шаардлагатай боловсон хүчнээр суралцаж байгаа болон Удирдлагын академийн Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж буй хавсралтад заасан төрийн жинхэнэ албан хаагчдын сургалтын төлбөрт дэмжлэг үзүүлсүгэй.

2. Төлбөрт шаардагдах 7,200,000 (Долоон сая хоёр зуун мянга) төгрөгийг Орон нутгийн хөрөнгө оруулалт “Хүний нөөцийг хөгжүүлэх” дэд хөтөлбөрийн зардлаас зарцуулахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Доржбат), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Энхтайван) нарт тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4823100477

Дундговь аймгийн Засаг даргын 2023 оны  
04 дугаар сарын 09 -ны өдрийн 17 дугаар  
захирамжийн хавсралт

СУРГАЛТЫН ТӨЛБӨРИЙН ДЭМЖЛЭГТ ХАМРАГДАХ  
АЛБАН ХААГЧДЫН НЭРС

| № | Овог нэр      | Албан тушаал  | Сургалтын төлбөрийн мөнгөн дүн |
|---|---------------|---|--------------------------------|
| 1 | Б.Дашдорж     | ШШГГ-ын ахлах шийдвэр гүйцэтгэгч                          | 2,340,000                      |
| 2 | Ж.Очирбат     | Адаацаг сумын ЗДТГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч | 1,620,000                      |
| 3 | Ж.Түмэндэлгэр | Аймгийн ИТХ-ын ахлах мэргэжилтэн                          | 1,620,000                      |
| 4 | Б.Энхдөл      | Хүнс хөдөө аж ахуйн газрын нягтлан бодогч                 | 1,620,000                      |
|   |               | <b>Нийт дүн:</b>  | <b>7,200,000</b>               |